

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр, Пүрэв гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-11</i>
<hr/>	
<i>1. “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>4-8</i>
<i>2. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нарын 19 гишүүн 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>8-11</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 07 дугаар сарын 06-ны өдөр  
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл-/**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61,1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Ц.Даваасүрэн, Т.Доржханд;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Ундрэм, Ч.Хүрэлбаатар, Т.Энхтүвшин.

**Нэг. “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Пүрэвсүрэн, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Итгэлт, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ц.Одхүү, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Маркетинг, борлуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Серикжан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

**Ц.Цэрэнпунцаг:** “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 7

Бүгд: 12  
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нарын 19 гишүүн 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, референт А.Хонгорзул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

**Ц.Цэрэнпунцаг:** “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 35 минут үргэлжилж, 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 11 цаг 20 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим, 10 цаг 45 минут

### ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ц.Цэрэнпунцаг:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Ингээд хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Өнөөдөр Чинбатын Ундрам гишүүн өвчтэй. Энхбаяр гишүүн гадаадад томилолттой байна. Ингээд бусад гишүүд хүрэлцэн ирж өнөөдрийн Байнгын хорооны ирц 61,1 хувьтай бүрэлдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, нэн яаралтай/

2. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нарын 19 гишүүн 2023 оны 7 сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг гэсэн 2 асуудлыг хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

**“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямбаатар сайд танилцуулна. Ажлын хэсгийнхнийг оруулж байгаарай. Ганбат дарга байна уу. Ганбат даргыг дуудаарай. Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Жавхлан танилцуулна. Сайдын микрофон өгнө үү. Нямбаатар сайд орж ирсэн тул Нямбаатар сайд танилцуулгаа хийнэ үү. Нямбаатар сайдын микрофоныг нээж өгье өө. Нямбаатар сайдын микрофоныг нээе.

**Х.Нямбаатар:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол улсын Ерөнхий сайдын 2023 оны 109 дүгээр захирамжаар Гашуунсухайт-Ганц мод боомтын хил холболтын төмөр замын ТЭЗҮ, зураг төслийн болон барилга байгууламжийг цогцоор нь барих ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Тус ажлын хэсэг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, “Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор Гашуун сухайт Ганц мод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлд зарчмын шинжтэй дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгахаар тусгасан. Үүнд:

1 дүгээрт, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг судлах, хэрэгжилтийг эрчимжүүлэх,

2 дугаарт Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганцмод боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч төрийн өмчит компаниар гүйцэтгүүлж холбогдох зардлыг Эрдэнэс таван толгой Хувьцаат компанийн өөрийн борлуулалтын орлогоос санхүүжүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганцмод төмөр замын өртөө хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч Төрийн өмчит компани болон Эрдэнэс таван толгой компанийн хооронд үе шаттай жил бүр 20 сая тонн хүртэлх нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой зах зээлийн зарчимд нийцүүлэн худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг зөвшөөрөх, Таван толгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглах, олборлолт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг авч, хэрэгжилтийг тгалигнахыг Засгийн газарт даалгасан болно.

Түүнчлэн уг тогтоолын дагуу аливаа гэрээг ашигт малтмалын түүхий эдээр төлөх нөхцөл буюу оффтейкээр байгуулахгүй байхаар тусгалаа.

Тогтоолын төсөл батлагдсанаар Таван толгойн бүлэг ордын үнэ цэн өсөх, тээврийн өртөг зардал буурах, уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтээс үүсэж буй байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл буурах, төсвийн орлого болон валютын нөөц нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

“Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Ц.Цэрэнпунцаг:** Нямбаатар сайд баярлалаа.

Ингээд гишүүн ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. П.Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Н.Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч, Итгэлт Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Түвшинжаргал Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга, Пүрэвсүрэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Төсөл санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Ингээд Ганхуяг гишүүний микрофоныг өгье. Асуултаа асууна уу.

**Х.Ганхуяг:** Нямбаатар сайдаас саяын тэр квоттой холбоотой асуултыг асуух гээд байна. 20 хувь гэдэг нь яг юуны квот юм бол. Энийг тодруулчихмаар байдаг. Тэгж байгаад дахиад тодруулъя.

**Ц.Цэрэнпунцаг:** Нямбаатар сайд.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. 2022 онд Эрдэнэс Тавантолгой, Тавантолгой төмөр зам, Чайна Энерджи компанийн хооронд байгуулсан Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улсын Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах талаар хамтран ажиллах ерөнхий хэлэлцээрийн нийтлэг үндэслэлд Чайна Энерджи компани ЭГТ компани хил

дамнасан төмөр зам ашиглалтад орохоос өмнө жил бүр 5 сая тонн, дараа жилээс нь коксжих нүүрс худалдах, худалдан авах гэрээ урт хугацаатай байгуулах, төмөр зам ашиглалтад орсны дараа 20 сая тонн нүүрс худалдах, худалдан авах ийм гэрээ байгуулах талаар зөвшилцөлд хүрснийг энэ гэрээгээр дурдсан байгаа юм. Тэгэхээр зүгээр би зүгээр ажлын хэсгийнхэнд эргээд өөрөө боловсруулчихаад л өөрөө өөртөө шүүмжлэлтэй хандах гээд байна. Энд ерөөсөө хүртэлх гэж үг байхгүй байхгүй юу Сайнзориг оо. 1 дүгээрт энийг бид нар энэ хүртэлх гэдэг үг бол бас нэг талдаа өөрийнхөө эдийн засгийг боомилж байгаа л хэлбэрийн зохицуулалт байх шиг байна. Энийг манай Ганхуяг гишүүн их тийм гярхай ажиглаж харсан байна.

2 дугаарт юу гэхээр сая Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийсэн Ерөнхий сайдын айлчлалын үеэр манай өнөөдрийн зарж, борлуулж байгаа нүүрсний квотод энэ квот орохгүйгээр анлимтэд явахаар айлын талтай тохиролцсон юм. Тэгэхээр энэ бол бас эдийн засагт том үр өгөөж өгөх юу байгаа.

2 дугаарт энэ ерөнхий гэрээнд дурдсанчлан зөвхөн коксжих гэж агуулгаар яриагүй шүү айлын тал. Эрчим хүчний нүүрс, семикокс, коксожсон нүүрсийг аль алийг нь та нарын баталсан тоо хязгаарын дотор бид нар худалдан авахад бэлэн байна гэсэн ийм агуулга байгаа. Тэгэхээр бид нар нөгөө баялгаа сурталчлах энэ тэр ойлголт бас үгүй болно л гэсэн санаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ганхуяг гишүүн тодруулж асууя.

**Х.Ганхуяг:** Нямбаатар сайд үндсэндээ бол миний тавих гэж байсан саналыг хариулчихлаа л даа. Тэгээд саяын Ерөнхий сайдын хийсэн айлчлал маш тийм чухал айлчлал боллоо. Тэгээд 7 сарын 9, 10-нд Монгол Улсад эдийн

засгийн форум зохион байгуулагдах үеэр бол бид нар үүд хаалга нээгдэж байгаа, боомтуудтай холбож байгаа, үүнтэй холбоотой бүтээн байгуулалтын ажлууд эхэлж байгаа энэ мессеж бол маш чухал мессежүүд байгаа. Энэ чинь зөвхөн үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн бүтээн байгуулалтуудаас гадна дараа дараагийн тэр бүтээн байгуулалтууд явагдах тэр бүсүүдэд, төмөр замын бүсүүдэд, боомтуудтай ойрхон бүсүүд бол илүү эдийн засгийн үр өгөөжүүд бол нэмэгдэнэ гэдэг нь бол ойлгомжтой болж байна. Тэгээд амжилт хүсье ээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Нямбаатар сайдаас саяынх дээр ганцхан товчхон асуудал тодруулаадахъя. Нэг юм тодорхой та хэллээ. Квот дээр бол ерөөсөө ямар ч дээшээ, доошоо хөдөлгөөн байхгүй. Квот бол батлагдсанаасаа батлагдана. Түүгээрээ авдагараа аваад л явчих юм байна. Энэ бол квотыг нь нэмж цаад талаас бол авах ийм комитмент гаргаж байгаа л асуудал юм байна. Тэгж ойлголоо. Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Зарим замын бүтээн байгуулалттай холбоотой, тэгээд хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой авах арга хэмжээ гээд. Ямар ч байсан энэ бүтээн байгуулалтаа эхлүүлж байна гэж ойлгох юм байна тийм үү.

1 дүгээрт энэ 20 саяыг чинь бас ойлгосонгүй ээ. 4 дээр ингэж байна Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганцмод төмөр замын өртөө хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч төрийн өмчит компани гэж байна. Төрийн өмчит компани. Хятадын компани байна тийм үү. Өөрөөр хэлбэл өртөө хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч гэдэг чинь яг хил дамнаж байгаа төмөр зам барьж байгаа, барих буюу бариад өмчлөгч нь бол таарах гээд байна. Энэ компанид бид нар 20 сая тонн нүүрс зарах юм байна жил болгон. Төмөр замын өмчлөгч компани нь авах юм уу.

Миний мэдэж байгаагаар Монгол, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын нэлээн өндөр шатны хэлэлцээрт төмөр замаа хамтарч хийе, бас худалдаа дээр хамтаръя, хуучнаар Чайна Энержи гэдэг компани одоогоор Энержи ямар юм компани билээ болоод өөрчлөгдсөн энэ компани гол худалдан авагч нь байгаад 20 сая хүртэл тонныг жил болгон нүүрс худалдан авна гэсэн нэг иймэрхүү зүйлийн гэрээ байх ёстой. Тэгээд одоо бол энэ 20 сая чинь төмөр замын компани болж хувирч байгаа юм уу. Нэг компани уу. Тэгвэл энийг нэг тодруулж өгөөч.

2 дугаарт энэ боомтын нөгөө холболтын цэгүүд маань яг бүр эцсийн вариантаар гүйцсэн байгаа юу.

3 дугаарт яг энэ холболтын хил дамнасан төмөр зам дээр хөрөнгө оруулалтууд маань хаанаас орох гэж байгаа билээ. Хэдий хэмжээний хөрөнгө оруулалт орох гээд байгаа билээ. Хамтарч хийх гээд байгаа юу эсвэл Чайна Энержи цаад талаасаа хийх гээд байна уу. Холболт маань яг ямар хэмжээнд явж байна. Энэ дээр нэг хариулт өгөөч.

**Ц.Цэрэнпунцаг:** Нямбаатар сайд хариулъя.

**Х.Нямбаатар:** Юу юм байна аа Бат-Эрдэнэ сайд аа, Бид нар сая урд Хятадад очихдоо Чайна Энержи компанитай бас очиж уулзалт хийсэн. Чайна энержи компани Цэрэнпунцаг дарга аа, жилд 750 сая тонн нүүрс худалдаж авч, борлуулдаг ийм компани юм байна. Манай жилийн дундаж борлуулалтыг бол 25 жил бид нар зардаг нүүрсийг л жилдээ эднийх авч хэрэглэдэг л ийм айл юм байна. Тэгээд энэ айл 4,5 мянган км төмөр зам эзэмшдэг юм байна. Түүний хамгийн хойд үзүүр нь Ганцмодны боомт дээрээ ирчихсэн байгаа юм байна Бат-Эрдэнэ сайд аа. Тэгэхээр энэ компани өөрөө энэ төмөр замын суурь дэд бүтцийг эзэмшдэг компани гэж ойлгож болно.

Энэ компанитай бид нар 1 дүгээрт хилээ холбож, хил дамнасан боомтын төмөр замаа барьж байгуулахын тулд нөхдүүд биднээс баталгаа шаардаж байгаа нь бид нэгэнт барьсан төмөр замаа тогтвортой тээвэртэй байлгах шаардлагатай. Тийм учраас жилд 20-оос доошгүй сая тонн нүүрс бид нарт тогтвортой борлуулна гэдгээ гэрээлье гэдэг ийм шаардлага тавьж байгаа.

2 дугаарт хил дамнасан байгууламжийг бид Чайна Энержигийн компаниар өөрөөр нь гүйцэтгүүлье. Яагаад гэвэл энэ 1 дүгээрт 2 улсын хил дамнаж баригдах олон зөвшөөрөлтэй ийм зам 703 гэдэг хилийн баганаар гарах хил холболтын цэгээ тохирчихсон, 2 талдаа өргөн нарийн 2 царигаар 2 улсын хил рүү зөрж орно. 2 талдаа нүүрс терминалын том байгууламжууд баригдах, манай талд баригдах төмөр замын суурь бүтцийн ажил бол нэлээд тийм төвөгшил ихтэй. Стакадан гүүр 40 метр орчим Стакадан гүүр 2 хос тийм гүүр баригдаж, манай улсын хил рүү хос зам орж ирж, бид нарын нөгөө тавьсан үзүүртэй холбогдоно. Эргээд нөгөө талдаа зөрөөд Ганцмодны боомт руугаа зөрж гарсан ийм байгууламж байх. Бүгдийг нь барьж дуусгаад, гүүр барина. Ашиглалтад оруулаад, тэгээд яг хилийн тэг цэг хүртэл манай төмөр замын тариф бодогдоно. Хилийн тэг цэгээс цаашаа тэдний төмөр замын тариф бодогдоод явахаар ийм тохиролцоотой явж байгаа. Дээр нь дан коксжих нүүрс биш эрчим хүчний нүүрстэй хольж авах ийм бас агуулга яригдаж байгаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе.

**Ж.Бат-Эрдэнэ:** Маш олон жилийн дараа нэг учраа олж байгаа юм байна. Нямбаатар сайд аа, би наад асуудлуудыг чинь мэдэлгүй яах вэ дээ. Ганцхан өөрөөр чинь энэ асуудлуудыг тайлбарлаж хэлүүлэх гэсэн юм. Бүгд Найрамдах Хятад Ард Улстай бид нар төмөр замаа



хамтарна гээд үндсэндээ гол гаргачихсан улс байхгүй юу. Олон жилийн хугацаанд. Цаанаасаа төмөр замаа барьж авчраад Чайна Энержи компани нь төмөр замаа авчраад тулгачихсан, тулгачхаад бас 8 жил, 10-аад жил болж байгаа байхгүй юу. 8 жил. Тэгээд нүүрснийхээ олборлолт дээр ч бас хамтаръя, ер нь бол борлуулалт дээр ч хамтаръя гээд ингээд олон жил бид нар бол энэ айлгыг хөлдөөгөөд, хөшөөгөөд зогсоочихсон. Одоо нэг асуудлаа шийдэж байгаа юм байна гэж ойлголоо. Ямар ч л байсан энэ улсдаа 20 сая тонныхоо урьд өмнө ярьж байсан хэмжээндээ нүүрснийхээ борлуулалтыг хамтраад хийж байгаа юм байна гэж ойлголоо.

**Ц.Цэрэнпунцаг:** Гишүүд асуулт асууж дууслаа. Ингээд тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Гишүүд үг үг хэлж дууслаа. Ингээд санал хураалт явуулж эхэлье ээ.

“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Жавхлан гишүүн та горимын санал гарга даа.

**Б.Жавхлан:** Байнгын хорооны дарга аа, та сая өөрөө харлаа шүү дээ би дараад болсонгүй. Манай Засгийн газраас орж ирж байгаа асуудал учраас бид бүгдээрээ дэмжилгүй яах вэ. Энэ болохгүй байна шүү. Тэгээд дахиж явуулж өгөх үү. Эсвэл би картаа сугалаад өөр юун дээр суугаадахъя. Тэгээд та санал хураалтаа дахиж явуулж өгөөч.

**Ц.Цэрэнпунцаг:** Жавхлан гишүүн та наад төхөөрөмжөө солиодох, тэгээд ирцдээ ороодох. Тэгээд саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү гэсэн Жавхлан сайдын саналаар санал хураалт явуулъя. Жавхлан сайд гаргачихсан. Тэгэхлээр бид нар саяын хураасан санал хураалтаа хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 70 хувь нь дэмжиж саяын санал хураалт хүчингүй боллоо.

Ингээд саяын санал хураалт хүчингүй болсон учраас дахин санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 70 хувь дэмжиж, санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулна.

“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дууслаа.

11.06 цаг.

Ингээд дараагийнхаа асуудалд оръё. Хэлэлцэх асуудал 2.

**“Хянан шалгах Түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямбаатар танилцуулна. Нямбаатар сайдын микрофоныг өгнө үү.

**Х.Нямбаатар:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг Монгол улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, байгалийн бусад баялаг, гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна гэж, 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн нийт гишүүдийн 4-ний 1-ээс доошгүй нь Хянан шалгах түр хороог байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулж, уг хороог байгуулж болно гэж тус тус заасан.

Төрийн болон орон нутгийн өмчит төрийн өмчийн оролцоотой компаниудад гарч байгаа нүүрсний хулгайн асуудал нь нийтийн эрх ашиг, сонирхлыг хөндсөн тодорхой асуудал бөгөөд дээрх хуульд заасны дагуу Улсын Их Хурлын нийт гишүүний 4-ний 1-ээс доошгүй нь буюу 19 гишүүн энэхүү асуудлаар Хянан шалгах түр хороо байгуулах санал гаргаад байна.

Төрийн болон орон нутгийн өмчит төрийн өмчийн оролцоотой компаниуд ялангуяа төрийн өмчит Эрдэнэс Тавантолгой ХК, орон нутгийн өмчийн оролцоотой Тавантолгой ХК-уудад гарсан нүүрсний хулгайн гэх асуудлаар иргэд, олон нийтийн дунд үүсээд байгаа эргэлзээтэй, мөн Монгол Улсад хохирол учруулсан байж болзошгүй гэмт хэргийн шинжтэй мэдээллүүдийг тодорхой болгох, хууль хяналтын байгууллагуудад шалгагдаж байгаа нүүрсний хулгайтай холбоотой хэргүүдийн мөрдөн байцаах ажиллагааг хугацаа алдалгүй яаралтай явуулахад Улсын Их Хурлын зүгээс дэмжлэг үзүүлэх нь нэн чухал байна.

Үүний тулд Улсын Их Хурлаас төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ,

худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах арга хэмжээг авах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын даргын 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 107 дугаар захирамжаар нүүрсний хулгайн асуудлыг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу үр дүнтэй хянан шалгах, ард иргэд, иргэний нийгмийн байгууллын хүсэлт, шаардлагын хүрээнд олон нийтийг ил тод, бодитой мэдээллээр хангах, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нүүрсний худалдан авалт, тээвэрлэлт, гаалийн бүрдүүлэлт, экспорт, холбогдох зөвшөөрөл, хяналтын асуудлаар Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах, бэлтгэл хангах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Энэхүү ажлын хэсгээс ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан гишүүд нүүрсний хулгайтай холбоотой асуудлаар дагнасан хяналт шалгалт явуулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог байгуулан ажиллуулж, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулах тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Түр хороо байгуулах санал, дүгнэлтийг гаргасан.

Иймд Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасныг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит төрийн өмчийн оролцоотой компаниудын нүүрсний хулгайтай холбоотой асуудлаар дагнасан хяналт шалгалт эрчимтэй явуулах, цуглуулсан нотлох баримтыг шинжлэн

судлах нээлттэй сонсголыг үр дүнтэй зохион байгуулж иргэдийг мэдээллээр хангах, тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах тогтоолын төслийг боловсруулж танилцуулж байна. Уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Ц.Цэрэнпунцаг:** Нямбаатар сайд баярлалаа. Ингээд танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Оюунчимэг гишүүн. Уучлаарай. Оюунчимэг гишүүнээр тасалъя. Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Ганболд гишүүнээр ахлуулаад яг энэ нүүрстэй холбоотой, ялангуяа хил, гаальтай холбоотой асуудлаар нь ер нь ажлын хэсэг гараад, бараг Хянан шалгах түр хороо шүү дээ тэр чинь. Бас тэгээд нэлээд олон баримт бичгүүд цуглуулсан байх. Гэхдээ гол нь нөгөө хил, гааль дээр орж ирж байгаатай холбоотой гэсэн. Одоо бол төрийн болоод орон нутгийн өмч оролцоотой компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт гээд нэлээн өргөн хүрээнд энэ Хянан шалгах түр хороог байгуулаад ажиллаж байгаа юм байна. Дэмжиж байна. Энийг угаасаа цаг нь болчихсон байгаа. Харин энэ дээрээ дандаа Хууль зүйн байнгын хорооны гишүүд байна шүү дээ. Тэгээд Эдийн засгийн байнгын хороо энэ асуудлыг шийдэх гэж байгаа бол Эдийн засгийн байнгын хорооноос ганц Б.Энхбаяр гишүүн л гэж байна. Гэхдээ Б.Энхбаяр гишүүн чинь өөрөө Хууль зүйн байнгын хорооны дарга хүн л дээ. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хорооноос хүн оруулах саналтай байна. Би өөрөө жишээлбэл орж ажиллах сонирхолтой байна. Энэ дээр.

**Ц.Цэрэнпунцаг:** Оюунчимэг гишүүний саналыг бас би дэмжиж байна. Ер нь ингээд ажлын хэсгээ

өргөтгөөд Эдийн засгийнхаа байнгын хорооноос гишүүд орж ажиллуулах ёстой. Энийг нь ажлын хэсэг байгуулагдаад явахаар зэрэг ... би нэг хуулийн лавлагаа танилцуулъя. Их Хурлын тухай хуулийн 11.1, 11.2-т заасан олонх Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11.3-д заасан цөөнхийн төлөөлөл энэ хуулийн 34.2-т заасан зарчмын дагуу Түр хорооны бүрэлдэхүүнд оруулах гишүүдийн нэрийг өөрөө тогтоож, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ. Байнгын хороо ирүүлсэн нэрийг өөрчлөхгүйгээр хэлэлцэнэ гэсэн юм байна. Тэгэхээр нэрд өөрчлөлт оруулж болохооргүй юм байна даа. Тэгэхээр яах юм бол.

Энхбаяр гишүүн, Доржханд гишүүн, Цогтгэрэл гэсэн гишүүд Эдийн засгийн байнгын хооронд байгаа.

Би тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Та бүхэнд тогтоолын төслийг уншаад танилцуулаадахъя.

Хянан шалгах түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит

чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр, сарын 6 сарын хугацаатайгаар байгуулсугай.

**Олонхийг төлөөлөн:**

Э.Бат-Амгалан-Улсын Их Хурлын гишүүн  
Ж.Батжаргал-Улсын Их Хурлын гишүүн  
Б.Жаргалмаа -Улсын Их Хурлын гишүүн  
Х.Нямбаатар -Улсын Их Хурлын гишүүн  
Ж.Сүхбаатар -Улсын Их Хурлын гишүүн  
Б.Энхбаяр-Улсын Их Хурлын гишүүн

**Цөөнхийг төлөөлөн:**

С.Ганбаатар-Улсын Их Хурлын гишүүн  
Д.Ганбат -Улсын Их Хурлын гишүүн  
Т.Доржханд-Улсын Их Хурлын гишүүн  
О.Цогтгэрэл-Улсын Их Хурлын гишүүн

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани, орон нутгийн өмчийн оролцоотой “Тавантолгой” хувьцаат компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагааг иж бүрэн хянан шалгахгаар тогтоосугай

3.Энэ тогтоолыг 2023 оны өдрийг нь тавиагүй байна. Хэднээс яах юм. Өнөөдрөөр тавьчих уу. Маргааш. 2023 он ... энэ тогтоолыг ердийн горимоор хүчин төгөлдөр болгоё. Төсөлд ирсэн 3 дахь зүйл, хугацааг нь өөрчлөөд ердийн горимоор явах болгоод ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт явуулж эхэлъе.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлуулахыг

дэмжъе гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 63,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор танилцуулна.

“Хяналт шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна. Өмнөх тогтоолын төслийг манай байнгын хорооноос гарч байгаа санал, дүгнэлтийг чуулган дээр Ж.Бат-Эрдэнэ гишүүн танилцуулах байсан. Өнөрболор гишүүн болгож өөрчилсөн шүү.

Мөн 2 дахь тогтоолын төслийг адилхан Өнөрболор гишүүн танилцуулна. Тэгвэл 2 дахийг нь Оюунчимэг гишүүн та танилцуулчих.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд Оюунчимэг гишүүн уншиж танилцуулна.

Ингээд өнөөдрийн Эдийн засгийнбайнгын хорооны хуралдаан үүгээр өндөрлөж байна. Ингээд хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа.

11.20 цаг.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ